



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Дорноговь аймаг дахь Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын хураангуй тайлан

Аудитын код: ДГА-2022/119/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:
www.audit.mn

Сайншанд сум
2022 он

Дарга, тэргүүлэх аудитор: Т.Ган-Өлзий

Утас: 70522734 Цахим хаяг: gan-ulziit@audit.gov.mn

Аудитын менежер: У.Оюунтүлхүүр

Утас: 70523020 Цахим хаяг: oyuntulkhuur.u@audit.gov.mn

Аудитор: Б.Алтанзул

Утас: 70523020 Цахим хаяг: altanzulb@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



**ДОРНОГОВЬ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

Орон нутгийн өмчийн III байр, Залуучууд гудамж,
3 дугаар баг, Сайншанд сум, Дорноговь аймаг, 44103,
Утас: (705) 2-27-34

Вэб сайт: dornogovi@audit.gov.mn

2022.02.25 № 46/141

танай _____ -ны № _____ -т

ДОРНОГОВЬ АЙМАГ ДАХЬ ШҮҮХИЙН
ШИЙДВЭР ГҮЙЦЭТГЭХ ГАЗРЫН ДАРГА,
ДЭД ХУРАНДАА У.ЭНХТҮВШИН ТАНАА

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Дорноговь аймаг дахь шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дорноговь аймаг дахь шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.


Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэл гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР _____ Т.ГАН-ӨЛЗИЙ



010020027

Нэг. Санхүүгийн ба төсвийн гүйцэтгэлийн тайлангийн гол үзүүлэлтүүд

/сая төгрөгөөр/

Үзүүлэлт	2020.12.31	2021.12.31
Санхүүгийн байдлын тайлан		
Эргэлтийн хөрөнгийн дүн	58.5	78.2
Эргэлтийн бус хөрөнгийн дүн	452.6	472.7
Нийт хөрөнгийн дүн	511.1	550.9
Нийт өр төлбөрийн дүн	0.8	0.9
Цэвэр хөрөнгө/өмчийн дүн	510.3	550.0
Өр төлбөр, цэвэр хөрөнгө/өмчийн дүн	511.1	550.9
Санхүүгийн үр дүнгийн тайлан		
Үйл ажиллагааны орлогын дүн	614.7	632.9
Үйл ажиллагааны зардлын дүн	662.1	587.4
Үйл ажиллагааны үр дүн	-47.4	45.5
Үйл ажиллагааны бус үр дүн	-	-5.8
Үйл ажиллагааны нийт үр дүн	-47.4	39.7
Мөнгөн гүйлгээний тайлан		
Үйл ажиллагааны мөнгөн орлогын дүн	596.2	584.3
Үйл ажиллагааны мөнгөн зарлагын дүн	594.9	579.2
Үйл ажиллагааны ЦМГ	1.3	5.1
Хөрөнгө оруулалтын ЦМГ	-0.5	-3.9
Санхүүгийн ажиллагааны ЦМГ	-	-
Нийт цэвэр мөнгөн гүйлгээ	0.8	1.2
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	0.8
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0.8	2.0
Цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан		
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	557.6	510.3
Тайлант оны үр дүн	-47.4	39.7
Эцсийн үлдэгдэл	510.2	550.0
Төсвийн гүйцэтгэлийн тайлан		
Нийт зарлага ба цэвэр зээлийн дүн	566.9	572.8
Урсгал зардал	566.9	572.8
Хөрөнгийн зардал	-	-
Зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр	566.9	574.3
Улсын төсвөөс санхүүжих	563.2	572.1
Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	3.7	2.2

Хоёр. Байгууллага, түүний үйл ажиллагаа

Дорноговь аймаг дахь шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын эрхэм зорилго:

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын хэмжээнд 2021 оныг Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын үйл ажиллагаанд технологийн дэвшлийг нэвтрүүлж, албаны бэлэн байдал, сахилга хариуцлагыг дээшлүүлэх

Дорноговь аймаг дахь шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар нь дараах чиг үүргийг хэрэгжүүлдэг. Үүнд:

- иргэний, зөрчлийн, захиргааны хэргийн талаар гарсан шүүхийн шийдвэр, эрүүгийн хэргийн талаар гарсан шүүхийн шийтгэх тогтоол, шүүхээр баталгаажуулсан бусад байгууллагын шийдвэр гүйцэтгэх ажиллагааг мэргэжлийн удирдлагаар хангах, хяналт тавих
- цагдан хорих байрны үйл ажиллагааг нэгдсэн удирдлагаар хангах
- шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын үйл ажиллагаатай холбоотой журам, стандарт, заавар, зөвлөмжийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах
- байгууллага, алба хаагч, ажилтны аюулгүй байдлыг хангах, тэдний эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах
- үл хөдлөх, хөдлөх эд хөрөнгийн албадан дуудлага худалдааг зохион байгуулах
- алба хаагчийн үйл ажиллагааны талаарх гомдлыг шийдвэрлэх
- хариуцсан нутаг дэвсгэрийн хэмжээнд төлбөртэй этгээдийн бүртгэл, гүйцэтгэх баримт бичгийн тоо бүртгэл, хорихоос өөр төрлийн ял шийтгүүлсэн, албадлагын арга хэмжээ авагдсан этгээдийн цахим сан хөтлөх, улсын нэгдсэн бүртгэлд бүртгүүлэх
- баривчлах шийтгэл ногдуулсан шүүхийн шийдвэрийг гүйцэтгэх
- согтуурах, мансуурах донтой хүн болон эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээ авагдсан этгээдийг албадан эмчлэх эмнэлэгт хүргэх ажиллагааг гүйцэтгэх
- Монгол Улсын олон улсын гэрээнд заасан бол гадаад улсын болон олон улсын шүүх, арбитрын шийдвэрийг гүйцэтгэх ажиллагааг мэргэжлийн удирдлагаар хангах, хяналт тавих

Гурав. Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

Тайлант хугацаанд шилэн дансны нэгдсэн системд 151 төрлийн мэдээллээс 22 мэдээг хугацаа хоцроож мэдээлсэн, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн шийдвэр төрлийн нийт 9518.9 мянган төгрөгийн 7 тушаал гарснаас 8653.7 мянган төгрөгийн 5 тушаалыг шилэн дансны системд мэдээлээгүй байна.

Дөрөв. Дараагийн аудитаар анхаарах асуудал

Анхаарал татахуйц асуудал байхгүй байна.

Тав. Аудитын илрүүлэлт:

Аудитаар нийт 2.3 сая төгрөгийн 4 алдаа зөрчил илэрснээс, 2.2 сая төгрөгийн алдааг залруулж, 1 зөрчилд албан шаардлага, 0.1 сая төгрөгийн 2 зөрчилд зөвлөмж өгсөн.

Залруулсан алдаа

Хөрөнгө актлахдаа ТӨБЗГ-ын 576-р тогтоолын хавсралтын тоо ширхэгтэй дагуу актаагүй байсныг 2.2 сая төгрөгөөр залруулав.

Албан шаардлага

1. Шилэн дансны системд төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн 8.6 сая төгрөгийн 5 тушаалыг шилэн дансны системд мэдээлээгүй байна. Энэ нь “Шилэн дансны тухай” хуулийн 6.4.8-т “бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр, хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, концесс, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэрийг долоо хоногийн дотор мэдээлнэ” гэж заасныг зөрчсөн байна.

Зөвлөмж

1. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаатай холбоотой асуудал

1.1 Илрүүлэлт: Элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн 50.0 сая төгрөгийн 17 ширхэг хөрөнгө бүртгэлтэй байна. Энэ нь “Төрийн болон орон нутгийн өмчийн тухай” хуулийн 31.1-т “Төрийн өмчит хуулийн этгээд эзэмшилдээ байгаа илүүдэл үндсэн эд хөрөнгө, түүнчлэн ашиглах хугацаа нь дууссан буюу эсхүл осол гэмтэлд өртсөний улмаас зориулалтаар нь ашиглах боломжгүй болсон бөгөөд засаж, сэлбэж ашиглах нь эдийн засгийн хувьд үр ашиггүй нь тооцоогоор нотлогдсон эд хөрөнгийг худалдаж, шилжүүлж, акт тогтоон устгаж болно” гэж заасантай нийцэхгүй байна.

1.2 Өгсөн зөвлөмж: Элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн хөрөнгийг акталж данснаас хасах, эсхүл дахин шинээр үнэ тогтоож, ашиглалтын байдлыг тодорхой болгох

2. Худалдан авалттай холбоотой асуудал

2.1 Илрүүлэлт: Тайлант хугацаанд хийгдсэн 0.1 сая төгрөгийн зардлын гүйлгээг цахим төлбөрийн баримтгүйгээр /и-баримтын системд бүртгүүлээгүй/ хийсэн байна.

2.2 Өгсөн зөвлөмж: “Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай” хууль, нягтлан бодох бүртгэлийн тухай” хууль, Сангийн сайдын 2017 оны 347 тоот тушаалаар батлагдсан “Өмчийн бүх хэлбэрийн аж ахуйн нэгж, байгууллагад нийтлэг хэрэглэгдэх анхан шатны бүртгэлийн маягтыг нөхөх заавар”-ын холбогдох заалтуудыг хэрэгжүүлж, гүйлгээ хийхдээ и-баримтын бүрдлийг хангаж ажиллах

6.1 Төсвийн захирагчийн ангиллаар аудитад хамрагдсан байдал ба санал дүгнэлтийн мэдээлэл

№	Төсвийн захирагчийн ангилал	Байгууллага, нэгжийн тоо				Санал дүгнэлтийн хэлбэр			
		Аудитад хамрагдах	Үүнээс: Аудит хийсэн хэлбэр			Зөрчилгүй	Хязгаарлалттай	Сөрөг	Дүгнэлт өгөхөөс татгалзсан
			Санал дүгнэлт гаргасан	Түүвэрт хамруулсан	Аудит хийгээгүй				
A	1	2	3	4	5	7	8	9	10
1	ТШЗ	1	1			1			
НИЙТ									

6.2 Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл:

/сая төгрөгөөр/

№	Төсвийн захирагчийн ангилал	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
A	1	2	3	4	5	6	7	8	9	10	11
1	ТШЗ	4	2.3	1	2.2	0	0	1	0	2	0.1
НИЙТ		4	2.3	1	2.2	0	0	1	0	2	0.1